

Оршил

Төв аймгийн Баянцагаан сумын нутагт орших “Баянжонш” ХХК-ийн Чулуут цагаан дэлийн Зүүн салааны хайлуур жоншны орд нь МҮ-008595 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 150 км, Төв аймгийн Зуунмод хотоос зүүн урагш 117 км, Баянцагаан сумаас зүүн хойш 22 км-ийн зайд оршдог.

“Баянжонш” ХХК нь 2024 онд уул уурхайн зураг төсөл, судалгааны “Эмеральд инженеринг” ХХК-аар Чулуут цагаан дэлийн зүүн салааны ордыг ил болон далд аргаар ашиглах ТЭЗҮ-г хийлгэж, ЭБМЗ-ийн 2024 оны 04 сарын 24-ний өдрийн Т/24-12-02 тоот дүгнэлтээр баталгаажуулсан.

Тус компани мөн 2025 оны 6 сард ЧЦД-ийн зүүн салааны уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ /БОНБНҮ/-г баталгаажуулсан.

2025 оны Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталгаажуулан, уурхайд Улсын комисст хүлээлгэн өгч, уурхайд ил болон далд аргаар ашиглалт олборлолт явууллаа.

2025 оны уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл

ЧЦД-ийн зүүн салааны уурхай 2025 онд уулын ажлын төлөвлөгөөгөөр хүдрийн 7-р биетийн 2,0 га талбайд олборлолт явуулж, 273,62 мян м3 хөрс хуулж, 95,2 мян тн хүдэр олборлож боловсруулж, 75%-ийн дундаж агуулгатай 40000 тн жонш, 35% агуулгатай хүдэр 40000 тн-ыг гаргаж ОХУ болон БНХАУ-д борлуулахаар тусгасан.

Уурхай нь 2025 онд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хүдрийн 7-р биетийн 2,0 га талбайгаас: ил уурхайгаар 185,197 мян м3 хөрс хуулж, 95,2 мян тн хүдэр олборлож, далд уурхайгаар 1365,9 м малталт нэвтэрч, 10717,66 тн хүдэр олборлож, эндээс 30-50 хувийн агуулгатай 19030,95 тн хүдэр гаргаж экспортлож, дотоодод “Монголчехметалл” ХХК-ийн Чулуут цагаан дэлийн хайлуур жоншны Баяжуулах үйлдвэрт 50000 тн хүдрийг борлуулсан.

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайгаас хүдэр олборлох, ачиж тээвэрлэх үед тоос босож хөрс, ургамал, орчныг дарах, ажиллагсад, ойр байгаа нутгийн иргэдийн амьсгалах агаар бохирдох тул тоосжилтын нөлөөллийг бууруулах зорилгоор 2025 онд дараах арга хэмжээг авсан:

1. ЧЦД уурхайгаас Мааньт дахь борлуулалтын хэсэг хүртэлх 48 км хайрган хучилттай замыг засварлахад хүдэр борлуулалтын 300 сая төгрөгийг хувь нэмэр оруулсан.
2. Мөн уурхайн технологийн замыг хайрган хучилттай болгон стандартын дагуу 4,5 км зам тавьсан. Зам засварын ажилд тус компани 2025 онд нийт **400 сая** төгрөгийг зарцуулсан болно.
3. Уурхайн орчимд тоосжилтийг дарах зорилгоор замыг усалж байсан. Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнд 2025 онд **400,0 сая төгрөг** зарцуулсан.

2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Чулуут цагаан дэлийн зүүн салааны уурхай 2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд: 7-р биетийн баруун хойд хэсэгт 0,4 га талбайд дотоод овоолгоор 3000 м³ хөрс дүүргэж түрж, техникийн нөхөн сэргээлт хийхээр тусгасан. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 3000 мод тарих, Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтээр Баянцагаан сумын 1-р багийн нутагт орших Өлзийт нуурын эрэг дагуух хогийг цэвэрлэж зайлуулах ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөж, баталгаажуулсан.

2025 онд дотоод овоолгоор ба 3000 м³ хөрсийг дээр төлөвлөсөн 0,4 га талбайд дүүргэж тэгшилж, техникийн нөхөн сэргээлт хийсэн. Олборлолт явуулалт 0,5 га талбайн 500 м³ шимт хөрсийг хуулж, шимт хөрсний тусгай овоолго байгуулсан.

2025 онд тус компани “Тэрбум мод” төслийн хүрээнд уурхайн талбайд 2-3 м өндөртэй 2000 ш Улиас, 1,5 м өндөртэй 1000 ш Хайлаас, Бургас мод тарьсан.

Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтээр Баянцагаан сумын 1-р багийн нутагт орших Өлзийт нуурын 6 км эрэг дагуух хогийг цэвэрлэж, 4 тн хог хаягдлыг тээвэрлэж, Баянцагаан сумын хогийн цэгт аваачиж булсан.

Орчны хяналт шинжилгээ: уурхайн хөрсний тогтсон 2 цэгээс 1,1 ш дээж, унд ахуйд ашиглаж буй худгаас сар бүр усны 1 дээж авч Геологийн төв лаборатори болон ШУА-ийн Геоэкологи, Газарзүйн хүрээлэнд шинжилгээ хийлгэсэн.

БОНБНҮнэлгээнд тусгаснаар 2025 онд Байгаль орчныг хамгаалах санд нөхөн сэргээлтийн 50% -ийн барьцаа хөрөнгө 14,2 сая төгрөг байршуулсан.

2025 онд тус компани орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн зардалд нийт **332,2** сая төг зарцуулсан.